



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

23119 Чингис хот, Хэнтий аймаг,

Утас/Факс: 70-56-24-12

E-mail: infoazdtg@khentii.gov.mn

ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ж.ЭНХТӨР ТАНАА

2022.05.03 № 9/968

танай _____-ны № _____-т

Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2022 оны 04 дугаар сарын 13-ны өдөр тус сумын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах үйл ажиллагаа хийсэн дүнг удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Дүгнэлт: Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийг хяналтад аваагүйн улмаас аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд руу хууль, тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн биелэлт хугацаандаа явсан эсэх, ямар биелэлт яваад хэрхэн үнэлэгдэж байгааг мэддэггүй, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж эзэнжүүлээгүй байна. Байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний уялдааг хангаж, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг зөв тодорхойлох, сумын Засаг даргын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан дахин төлөвлөх шаардлагатай.

Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудасны хадгалалт, хамгаалалтын найдвартай байдал бүрэн хангагдаагүй. Албан хэргийн үйл ажиллагаанд бичиг хэргийн ажилтны хэрэглэх “Хуулбар үнэн, Байгууллагад баримт бичиг хүлээн авсан”, “Боловсруулсан, хянасан” дардасгүй. Хэвлэмэл хуудасны эхийг хянуулаагүй, хэвлэгч /принтер/-ээр хэвлэсэн стандартын бус хэвлэмэл хуудас ашиглаж байна. Хэвлэмэл хуудасны индекс батлаагүй, зарцуулалтад тавих хяналтыг хэрэгжүүлээгүй.

Зөвлөмж:

1. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдох заалтуудыг жил бүр жагсаалт гарган шинэчлэн батлуулж, биелэлтийг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг руу явуулахад хяналт тавьж ажиллах

2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг зөв тодорхойлох, төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд уялдуулан зорилтыг арга хэмжээ болгон нарийвчлан задалж боловсруулах

3. Аймгийн Засаг даргын 2021 оны А/105 дугаар захирамжийн хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг хэрэгжүүлэх аргачлал”-ын 3 дугаар зүйлийн 3.3.1-д заасны дагуу төсөвт байгууллагуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллах

2.

4. Үйлчилгээний стандартаа тогтмол мөрдөж ажиллах, Стандарт болон Хяналтын хуудас хэрэглэх журмаар сургалт хийж дахин танилцуулах

5. Үнэлгээний төхөөрөмжийн журмын хэрэгжилтийг хангаж ажиллах, АХХ-ын журамд заасны дагуу шаардлага хангасан тайлан, мэдээг заасан хугацаанд үнэн бодитой гаргаж сар бүрийн 25-ны дотор Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлэх

6. Удирдлагууд болон нийт албан хаагчид www.erp.e-mongolia.mn системийг тогтмол ашиглаж, удирдлагууд хяналт тавьж хэвших, босоо удирдлагатай албан хаагчдыг тухайн сумын ЗДТГ-т эрх үүсгэх, админ эрхтэй албан хаагч шинээр орсон ажилтан албан хаагчдыг системд бүртгэх, албан хаагчдын системд хандах эрхийг бүрэн гүйцэд, зөв тохируулах

7. Сумын мэдээлэл хүргэдэг хуудсуудыг идэвхтэй ажиллуулж тогтмол мэдээлэл оруулдаг байх, аймгийн Засаг даргын Тамгын газрын хуудсыг дагаж мэдээллийг сумын цахим хуудсуудаар хуваалцдаг байх, мэдээллийн самбар гаргаж, цаг үеийн мэдээллийг тогтмол байршуулдаг байх

8. Төсөвт байгууллагын нягтлан бодогч солигдсон тухай бүрт зөвшилцлийн бичгийг тогтмол авч байх, өдөр тутмын нябо журналд мемориалын баримтын бүрдүүлбэр дутууг гүйцээж архивын нэгжийг бүрэн үүсгэх. Үүнд: Өдөр бүрийн төсвийн багцын хуулга, баримт ашиглалтын хуудас, товъёог хийх.

9. Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоол, 2020 оны 246 дугаар тогтоол, Архивын ерөнхий газрын даргын 2016 оны А/142 дугаар тушаал, Монгол Улсын стандарт MNS 5140-2:2021 Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавигдах шаардлага, MNS 5140-3:2021 Баримт бичгийн хэвлэмэл хуудас, тэдгээрт бүрдлийг байрлуулахад тавигдах шаардлагыг баримтлан мөрдөж ажиллах

Зөвлөмжийн дагуу гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган биелэлтийг 2022 оны 05 сарын 13-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ГАНЧИМЭГ

